



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Бага тойруу 3, Засгийн газрын IV байр,
Утас: 26 04 37, Факс: (976) 6226 3230,
E-mail: info@audit.gov.mn, http://www.audit.mn

2017. 03. 15 № 3/472
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.3, 15 дугаар зүйлийн 15.1.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу "Өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ" ТӨХК-ийн 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, мөнгөн гүйлгээний, өмчийн өөрчлөлтийн тайлан болон холбогдох тодруулга бүхий санхүүгийн тайланд аудит хийв.

Үүрэг хариуцлагын талаархи мэдээлэл

"Өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ" ТӨХК-ийн удирдлага нь тайлант хугацааны санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт (СТОУС), Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт (НББОУС), түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмын дагуу үнэн зөв бэлтгэж, тайлагнах үүрэг хариуцлага хүлээнэ.

"Өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ" ТӨХК-ийн 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан нь үнэн зөв, бодитой илэрхийлэгдсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Санал дүгнэлтийн үндэслэл

Бид аудитыг Аудитын олон улсын стандарт, түүнд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журмын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр стандарт, журам нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар "Өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ" ТӨХК-ийн санхүүгийн тайлан, түүний тодруулга дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, программ хангамж, дотоод хяналтын систем, гол хууль тогтоомжуудын мөрдөлт, удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан болно.

Түрээсийн орлогыг бүртгэлд тусгаагүй, он дамжсан авлагын үлдэгдэлтэй, урьдчилж орсон орлогын байнгын ихээхэн хэмжээний үлдэгдэлтэй, орлогын албан татварын тооцооллыг буруу хийсэн, ойн арга хэмжээ, шагнал урамшуулалд хөрөнгө зарцуулсан, эзлжийн амралтын олговрын тооцооллыг буруу хийсэн, цалингийн нэмэгдлийг илүү олгосон, мөнгөн хөрөнгийн гүйлгээг дутуу бүртгэсэн, урт хугацаат

зээлийн гэрээ байгуулаагүй зэрэг зөрчлүүд нь санхүүгийн тайлангийн оршин байх, хамааралтай байх, иж бүрэн байх, хэмжилт, үнэн зөв байдал гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан материаллаг алдаагүй эсэхэд санал дүгнэлт өгөх хангалттай үндэслэл болно гэдэгт итгэлтэй байна.

Хязгаарлалттай санал дүгнэлт

Дээрх алдаа зөрчлийг эс тооцвол "Өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ" ТӨХК-ийн 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан болон санхүүгийн тайлангийн тодруулгуудыг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, НББОУС, СТОУС, түүнд нийцүүлж Сангийн сайдын баталсан заавар, журмын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ



“ӨМНӨД БҮСИЙН ЦАХИЛГААН ТҮГЭЭХ СҮЛЖЭЭ” ТӨХК-ИЙН 2016 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН

**Нэмэлт мэдээлэл авахыг хүсв:
дараахи хаягаар харилцана уу:**

САГ-ын дарга
Тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг
Утас:
Цахим хаяг:

Аудитын менежер Я.Самбууням

Утас:
Цахим хаяг:

Голден пэйж аудит ХХК
Захирал С.Оюунгэрэл
Аудитор Б.Одгэрэл
Утас: 99170900
70117179

Цахим хаяг:
goldenpageaudit@yahoo.com

ТАБ-ын хаяг: Үндэсний аудитын
газар

Байршил: Чингэлтэй дүүрэг
Цахим хуудас: www.audit.mn

2017 оны 3 дугаар сар

Аудитын тайлан

Хавсралт 1: Агуулга

Хавсралт 2: Аудитын гэрчилгээ

Хавсралт 3: Менежментийн захидал

Хавсралт 4: Аудит хийсэн санхүүгийн тайлан

АГУУЛГА

1. Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл
2. Байгууллагын хууль, эрх зүйн орчин
3. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа
4. Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн
5. Дотоод хяналт
6. Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар
7. Шилэн дансны мэдээлэл
8. Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар
9. Гол, онцлог гүйлгээний талаарх (тохиромжтой бол) тайлбар
10. Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар:
11. Материаллаг бус залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар:
12. Анхаарал татахуйц бусад чухал асуудал
13. Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд
14. Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл
15. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
16. Зөвлөмж
17. Аудитын гэрчилгээний тохирох загварын талаарх дүгнэлт

Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл:

Төсвийн тухай хуулийн 8.9.2, Төрийн аудитын тухай хуулийн 15.1.2 дахь заалтыг үндэслэн Төрийн аудитын тухай хуулийн 18.2 дугаар зүйлд заасан Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд “Өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК-ийн 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайланд ҮАГ-САГ/2017/14/СТА-ТӨҮГ/ аудит хийлээ.

Аудитыг Компанийн тухай, Төрийн аудитын тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандартын зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

“Өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК-ийн 2016 оны санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Санхүүгийн тайлагналын Олон улсын стандарт /СТОУС/, түүнд нийцүүлэн гаргасан төрийн өмчит хувьцаат компанийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төрийн өмчит хувьцаат компанийн захирал нь санхүүгийн тайлангаа СТОУС, түүнд нийцүүлсэн Сангийн сайдын холбогдох журмууд, төрийн өмчит хувьцаат компанийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, програм хангамжийн дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Тухайн санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, СТОУС-тай нийцүүлж материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

“Өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК-ийн 2016 оны санхүүгийн тайлангийн аудитыг 2016 оны 12 дугаар сарын 22-ноос 2017 оны 3 дугаар сарын 15-ны хооронд хийхээр төлөвлөн “Голден пэйж аудит” ХХК-ийн аудитын баг хэрэгжүүлэв. /ТАБ-СТА-А-9/

“Өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК-ийн 2016 оны санхүүгийн тайланг 2017 оны 2 дугаар сарын 15-нд “Голден пэйж аудит” ХХК-д ирүүлсэн байна.

“Голден пэйж аудит” ХХК аудитыг 2017 оны 2 дугаар сарын 15-наас 2017 оны 3 дугаар сарын 15-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2017 оны 3 дугаар сарын 20-нд “Өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК-ийн удирдлагад гардуулна.

Байгууллагын хууль, эрх зүйн орчин:

“Өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК-ийн захирал нь Монгол улсын “Төрийн болон орон нутгийн өмчийн тухай”, “Компанийн тухай”, “Хөдөлмөрийн тухай”, “Татварын ерөнхий хууль”, “Нийгмийн даатгалын багц хууль” болон Эрчим хүчний яамнаас гаргасан дүрэм, журам, тушаал, шийдвэрүүдийн

хүрээнд үйл ажиллагаагаа явуулж байна. Тайлант онд тухайн байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг гол хууль болох Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хууль өөрчлөгдсөн байна.

Байгууллагын зорилго, үйл ажиллагаа:

Монгол Улсын Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 15 дугаар зүйлд “Өөрт олгогдсон эд хөрөнгийн үндсэн дээр өөрийгөө санхүүжүүлэх зарчмаар ажиллаж бие даан иргэний гүйлгээнд ордог хуулийн этгээдийг аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар гэнэ” гэж тодорхойлсон байна.

Монгол Улсын Эрчим хүчний тухай хуулийн 17 дугаар зүйлд “... эрчим хүчээр зохицуулалттай хангах тусгай зөвшөөрлөөр хуулийн этгээдэд цахилгаан дулаан үйлдвэрлэх, дамжуулах, түгээх тусгай зөвшөөрөл эзэмшигчээс цахилгаан, дулаан худалдан авах, цахилгаан импортлох, цахилгаан, дулааныг хэрэглэгчид худалдах” гэж энэ байгууллагын зорилтыг тодорхойлсон байна.

Дээрх зорилтыг хэрэгжүүлэхийн тулд Монгол Улсын Компанийн тухай хуулийн 83 дугаар зүйлийн 1-д “Гүйцэтгэх удирдлага нь компанийн дүрэм болон төлөөлөн удирдах зөвлөлтэй байгуулсан гэрээнд заасан эрх хэмжээний дотор компанийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдан зохион байгуулна” гэж заасан байна. Мөн “Өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК-ийн зохион байгуулалтын ерөнхий бүтэц, орон тоог Хувьцаа эзэмшигчдийн хурлаас баталдаг. Компанийн дүрмийг Хувьцаа эзэмшигчдийн 2015 оны 4 дүгээр сарын 29-ний өдрийн 04 тоот тогтоолоор баталсан. Байгууллагын зорилго зорилтыг хэрэгжүүлэхийн тулд байгууллагын үйл ажиллагааны үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, бизнес төлөвлөгөөг Монгол Улсын Эрчим Хүчний Сайдаар батлуулан ажиллаж байна.

Байгууллагын удирдлагатай холбоотой хууль эрх зүйн баримт бичгийг судалсан бөгөөд байгууллагатай холбоотой Компанийн тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай, Эрчим хүчний тухай хуулиудыг хэрэгжүүлэн ажиллаж байна.

“Өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК-ийн үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд ТАБ-СТА-А-1 маягтад тодорхой тусгасан.

Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн:

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, СТОУС, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг шалгуур болгон ашиглав.

Аудитаар “Өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК-ийн 2016 оны санхүүгийн тайланд дүгнэлт өгөх үүднээс тус байгууллагын удирдлагын бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд дансдын уламжлалт эрсдэл болон хяналтын эрсдэлийг тогтоон тухайн байгууллагын зүгээс тавьж буй дотоод хяналтыг үнэлж баримтжууллаа. /ТАБ-СТА-А-5/

Санхүүгийн тайланг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, зарим гүйлгээ ихтэй томоохон дансдад түүвэрчилсэн байдлаар аудитын нарийвчилсан горим, сорил 62-г гүйцэтгэв. /ТАБ-СТА-В-3/

Тухайн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, системтэй танилцахад “Өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК-ийн санхүүгийн үйл ажиллагаанд хэрэглэгдэх нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулан мөрдөн ажиллаж байгаа бөгөөд энэхүү бүртгэлийн бодлогын баримт бичиг нь СТОУС-тай нийцсэн байна. Стандарттай нийцсэн бүртгэлийн бодлоготой, нягтлан бодох бүртгэлийн програмтай байна.

“Өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК-ийн санхүүгийн үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа компьютерийн системийн үйл ажиллагаатай асуулга явуулах аргаар танилцан түүний нарийн төвөгтэй байдлын үнэлгээг хийхэд бага буюу мэдээллийн технологийн мэргэжилтэнг оролцуулах шаардлагагүй гэсэн үнэлгээ авсан тул аудитыг шууд гүйцэтгэлээ. /ТАБ-СТА-В-2/

“Өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК-ийн санхүүгийн үйл ажиллагааг бүртгэх, хянах, боловсруулах үйл ажиллагааг санхүүгийн програмаар боловсруулан санхүүгийн тайлан бэлтгэх аргачлалын дагуу санхүүгийн тайланг гаргасан байна.

Дотоод хяналт:

Тус байгууллагын үйл ажиллагаанд тавих ерөнхий хяналтыг Эрчим хүчний яамны Эрчим Хүчний Зохицуулах хороо хэрэгжүүлдэг.

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хийсэн. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм. “Өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК-ийн дотоод хяналт эрсдэлийг төлөвлөлтийн үед бага гэж тооцсон ба дахин хянахад дотоод хяналт хангалтгүй байна.

Материаллаг байдлын түвшин:

“Өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК-ийн материаллаг байдлын түвшинг тодорхойлохдоо 2015 оны нийт зардал 4,481.1 сая төгрөгөөс материаллаг байдлын суурь болгон түүний 1 хувиар тооцож 44.81 сая төгрөг гэж тогтоосон.

Гүйцэтгэлийн шатанд материаллаг байдлын түвшинг дахин тооцоолж 2016 оны нийт хөрөнгө 15,061.7 сая төгрөгнөөс 1 хувиар тооцож 150.6 сая төгрөг гэж тогтоолоо.

Төрийн өмчит хувьцаат компанийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар:

“Өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК нь 2016 оны батлагдсан зорилтот түвшингийн хүрээнд үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулан мөрдөж ажилласан байна.

“Өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК нь 2016 онд үндсэн үйл ажиллагаанаас 4,833.5 сая, үндсэн бус үйл ажиллагаанаас 188.1 сая төгрөгийн орлого олжээ. Үүнээс борлуулалтын өртөг 3,903.7 сая төгрөг, борлуулалт маркетингийн зардал 5.7 сая төгрөг, ерөнхий ба удирдлагын зардал 951.0 сая төгрөг, үйл ажиллагааны бус зардалд 61.2 сая төгрөг зарцуулж 89.9 сая төгрөгийн ашигтай ажилласан байна.

2016 оны зорилтот түвшингээр 4,523.5 сая төгрөгийн борлуулалт хийж, 4,522.1 сая төгрөгийн зардал гаргаж 1.3 сая төгрөгийн цэвэр ашигтай ажиллахаар төлөвлөсөн бөгөөд гүйцэтгэлээр 5,021.7 сая төгрөгийн борлуулалт хийж 4,921.7 сая төгрөгийн зардал гаргаж, татвар төлөхийн өмнөх 99.9 сая төгрөгийн ашигтай ажиллаж, аж ахуйн нэгжийн орлогын албан татварт 9.9 сая төгрөг төлж, 89.9 сая төгрөгийн цэвэр ашигтай ажилласан байна. Борлуулалтын орлогын төлөвлөгөөг 111 хувь, цэвэр ашгийн төлөвлөгөөг 69.1 хувиар биелүүлсэн байна.

Шилэн дансны мэдээлэл

“Өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК нь улс, орон нутгийн өмчийн хөрөнгийг үр ашигтай захиран зарцуулах зорилгоор удирдлагын шийдвэр, үйл ажиллагаа ил тод, нээлттэй, ойлгомжтой байх, түүнд олон нийт хяналт тавих мэдээллийн тогтолцоог хуулийн дагуу хангасан талаар тодорхой мэдээлэл өгөхийн тулд “Шилэн дансны тухай” хуулийг хэрэгжүүлэн ажиллаж байна.

“Өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК нь www.shilendans.gov.mn вэб сайтад шилэн дансны мэдээллүүдээ тогтмол оруулдаг бөгөөд 2016 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөө болон тайлан, хөрөнгийн болон урсгал зардалд тусгагдсан арга хэмжээний тендерийн ерөнхий мэдээллүүд тавигдсан байна. Мөн хөрөнгө, мөнгө зарцуулах шийдвэрүүд, нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8, 9 дүгээр зүйлд заасан мэдэгдлүүдийг оруулсан. Их хэмжээнд тооцогдохуйц хэлцэлд гаргасан баталгаа, батлан даалтын мэдээлэл байхгүй гэсэн мэдээллүүдийг оруулсан байна.

Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар:

Аудитын төлөвлөгөөний дагуу аудитын 42 эрсдлийг тогтоож, батламж мэдэгдлүүдийн хүрээнд данс бүрээр нийт 62 нарийвчилсан горим, сорил гүйцэтгэв.

Үр дагаврыг тодорхойлж харвал: Түрээсийн орлогыг бүртгэлд тусгаагүй, он дамжсан авлагын үлдэгдэлтэй, урьдчилж орсон орлогын байнгын ихээхэн хэмжээний үлдэгдэлтэй, орлогын албан татварын тооцооллыг буруу хийсэн, ойн арга хэмжээ, шагнал урамшуулалд хөрөнгө зарцуулсан, ээлжийн амралтын олговрын тооцооллыг буруу хийсэн, цалингийн нэмэгдлийг илүү олгосон зэрэг

зөрчлүүд нь санхүүгийн тайлангийн оршин байх, хамааралтай байх, иж бүрэн байх, хэмжилт, үнэн зөв байдал гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Гол, онцлог гүйлгээний талаарх тайлбар:

“Өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК-ийн 2016 оны санхүүгийн тайлан материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэдгийг, түүнийг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, аудитын явцад санхүүгийн тайланд нөлөөлөхүйц хэмжээний мөнгөн хөрөнгө, үндсэн хөрөнгө, борлуулалтын орлого, түрээс, тээвэр шатахуун, шуудан холбоо, төлбөр хураамж зэрэг дансанд ажил гүйлгээ, үлдэгдэл, тооцооллуудыг түүвэрчлэн нарийвчилсан горим, сорилын аргаар шалгалаа. /ТАБ-СТА-В-3/

Дээд шатанд

1. Зорилтот түвшинг үндэслэлтэй судалгаа, шинжилгээтэй үнэн зөв хариуцлагатай хянаж баталгаажуулдаг байх. Үүнд:

А. Шугамын алдагдлыг багасгасан гэх үзүүлэлтээр сар бүр үр дүнгийн шагнал олгодог байна.

Б. Шугамын алдагдал багасгасан гэх үзүүлэлтээр жилийн үр дүнгийн цалин 0.5 сартай тэнцэх хэмжээний шагналт цалин олгодог.

В. “Алдагдалтай ажиллана” гэж зорилтот түвшинг баталдаг, алдагдалтай ажиллах ёстой гэсэн үндэслэл, үзэл баримтлан журам гарган үзүүлэлтээ хувиар дүгнэн жилийн үр дүнгийн цалинг 4 хүртэлх сараар тооцоолон шийдвэр гарган шагналт цалин олгодог байна. Энэ нь сарын үр дүн, жилийн үр дүнг шугамын алдагдал багасгасан, алдагдалтай ажиллаагүй гэсэн үзүүлэлтээр олгож байгаа журмыг өөрчлөн үндэслэлтэй зорилтот түвшинг баталдаг байх

Г. Хамтын гэрээ, хэлэлцээрээр 2-4 жил ажилласан хүнд удаан жилийн нэмэгдэл 15-20 хувийн нэмэгдэл цалинг баталж олгосон.

Д. Хамтын гэрээ хэлэлцээрээр Эрчим хүчний салбарын тэргүүний ажилтанд сар бүр 10,000 төгрөг олгож байгаа нь цалингийн нэмэгдлийг хэт хавтгайруулан олгож эрх үүргийг үндэслэл муутай хэрэгжүүлдэг байна. Энэ нь Засгийн газрын чиглэл, тогтоол, шийдвэрүүд, Төсвийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн тухай хуулийн үр ашигтай, хэмнэлттэй, хариуцлагатай байх зарчим алдагдах цаашлаад Үндсэн хуулийн хэм хэмжээ зөрчигдөхөд хүрчээ.

Төлөөлөн удирдах зөвлөлд

1. 2013 оноос 2016 оны эхний хагас жилийн хугацааны төлөөлөн удирдах зөвлөлийн тогтоол, шийдвэртэй танилцсан боловч үдэж хавтаслаагүй, дугаарлан архивлаагүй, архивын нэгж болгон хадгалаагүй, ТУЗ-ийн хурлын тэмдэглэл бүрэн гүйцэд биш дутуу байгаа байдал ажиглагдлаа.

2. Төлөөлөн удирдах зөвлөлийн тогтоолын огноо, шийдвэр зөрүүтэй байсан.

3. Төлөөлөн удирдах зөвлөлийн аудитын хорооны тайлан дүгнэлт байхгүй.

4. Төлөөлөн удирдах зөвлөл нь Компанийн тухай хуулийн 79.3.1, 79.3.2, 79.4.1, 79.4.2, 81.4, 81.5, 81.6, 82.2 зүйл заалтуудыг хэрэгжүүлэн ажиллаагүй байна.

Анхаарал татахуйц бусад чухал асуудал:

Хамтын гэрээ хэлэлцээр нэрийн дор эрчим хүчний салбарын төрийн өмчит аж ахуйн нэгж байгууллагын удирдлагууд, ажил олгогч эздийн холбоо, үйлдвэрчний байгууллагууд нэгдэн нийлж хамтарч шийдвэр гаргаж уг хэлэлцээр гэрээг мөрдөн ажиллаж байгаа нь Засгийн газрын чиг үүрэг, эрх, хэм хэмжээ, хууль, тогтоол, шийдвэр зөрчигдөхөд хүрч болзошгүй эрсдэлтэй.

Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд:

“Өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК-ийн эхлэлтийн балансад “Эрчим хүчний төсөл”-ийн 5303-MOG дугаартай дамжуулан зээлдүүлэх гэрээний 929.7 сая төгрөгийн урт хугацаат зээлийн өглөг “ДзДЦС”ТӨХК-аас шилжиж ирсэн. 2015 онд тус 2 байгууллага тооцоо нийлж уг зээлийн 242.8 сая төгрөгийг “ДзДЦС” ТӨХК хариуцахаар болж “ӨБЦТС” ТӨХК 686.9 сая төгрөгийн урт хугацаат зээлийн өглөгтэй байхаар тооцоо нийлсэн байна. Сангийн яам болон “Өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК-ийн хооронд байгуулсан урт хугацаат зээлийн гэрээ байхгүй байна.

Энэ урт хугацаат зээлийн талаар Сангийн яаманд лавлагаа хүссэн албан тоот илгээсэн боловч хариу хараахан ирээгүй болно.

Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар:

Санхүүгийн тайлангийн аудитаар хөндөгдсөн гол асуудлуудыг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Аудитын явцад материаллаг хэмжээний дараах алдаа илэрсэн байна. Үүнд:

1. Тендер сонгон шалгаруулалт болон Худалдан авах ажиллагаа холбогдох хууль, журмын дагуу үнэн зөв шударга явагдаагүй байна. ТУЗ-өөс сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх талаар шийдвэр гараагүй боловч сонирхлын зөрчилтэй хэлцэл хийсэн, тендерийн сонгон шалгаруулалт явуулахдаа үнэлгээний хороо хараат бус байдлаа алдсан байдал ажиглагдлаа. Энэ нь Компанийн тухай хууль болон Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуульд заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай, Компанийн тухай хуулийг мөрдөн ажиллах талаар зөвлөмж өгөх

2. Тайлант онд мөнгөн хөрөнгийн журналд 530.7 сая төгрөгийн харилцах дансны орлого, зарлагын гүйлгээг дутуу бүртгэж тайлагнасан байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14.4.1, 14.4.5-д “Нягтлан бодох бүртгэлд аж ахуйн бүх ажил гүйлгээ, бүх орлогыг заавал бүртгэнэ” гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: НББ-д бүх ажил гүйлгээг бүрэн тусгаж тайлагнах талаар албан шаардлага хүргүүлэх

Материаллаг бус дараах зөрчил илэрсэн байна. Үүнд:

1. Орлогын бүртгэлийн тайланд заалны орлогыг бүртгэж тайлагнаагүй. Харуулын бүртгэлээр спорт зааланд нийт 898 удаагийн оролтоор 13.7 мянган хүн 1.6 мянган цаг тоглосны түрээсийн орлого болох 15.6 сая төгрөгийн түрээсийн орлогыг бүртгэж тайлагнаагүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14.4.1, 14.4.5-д “Нягтлан бодох бүртгэлд аж ахуйн бүх ажил гүйлгээ, бүх орлогыг заавал бүртгэнэ” гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Бүртгэлд дутуу тусгасан түрээсийн орлогыг нөхөн төлүүлэх талаар төлбөрийн акт тогтоох

2. Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар тооцоолохдоо татвар ногдуулах орлогоос үйл ажиллагааны бус зардлыг хасаж тооцсоноос орлогын албан татвар 3.6 сая төгрөгөөр дутуу тооцоологдсон байна. Энэ нь санхүүгийн тайлангийн оршин байх, хэмжилт, иж бүрэн байх, үнэн зөв байдал, тайлагнал гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Аж ахуйн нэгжийн орлогын албан татварыг холбогдох хууль, тогтоомжийн дагуу үнэн зөв тооцоолон тайлагнах талаар албан шаардлага хүргүүлэх

3. Тайлант онд ойн арга хэмжээ болон шагнал урамшуулалд гүйцэтгэх захирлын тушаалаар 30.1 сая төгрөг зарцуулсан нь ЗГ-ын 2014 оны 5 дугаар сарын 10-ны өдрийн 147 тоот тогтоолын 3.6-д “улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр, ялангуяа төсвийн нэмэлт орлого, хандив болон тусламжийн орлогоор гадаад, дотоодын тойрон аялал, зугаалга, ой тэмдэглэх арга хэмжээ, урлагийн наадам, уралдаан тэмцээн зохион байгуулахгүй байх”, 4-р зүйлд “яам, агентлаг төсөвт байгууллагууд төв, орон нутгийн мэдээллийн хэрэгслээр дамжуулан төсвийн хөрөнгөөр олон нийтэд зайлшгүй мэдээлэх хууль тогтоомж, албан ёсны шийдвэр болон тэдгээрийн хэрэгжилтийг сурталчлан таниулахаас бусад зорилгоор өөрийн байгууллага, хамт олныг рекламдах, телевизийн шоу уралдаан, тэмцээн зохион байгуулах, цуврал олон ангит кино хийхгүй бөгөөд баяр ёслол, байгууллага, салбарын ой, тэмдэглэлт өдөр зохион байгуулахтай холбогдуулан төсвийн хөрөнгөөр цаасан мэндчилгээ илгээх, бэлэг дурсгалын зүйлс, цүнх, календарь зэрэг зүйлс бэлтгэх, ивээн тэтгэхийг хориглосугай” гэснийг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: ЗГ-ын 147 тоот тогтоолыг хэрэгжүүлэн ажиллах, ойн арга хэмжээ, шагнал урамшуулалд зарцуулсан 30.1 сая төгрөгийг нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоох

4. Тайлант онд ажиллагсдын ээлжийн амралтын тооцоолол хийхдээ цалин хөлсөнд унаа хоолны нэмэгдлийг оруулан тооцсон, дундаж хоногийн цалинг тооцоолохдоо ажилласан хоногт хуваан тооцсоноос 1.8 сая төгрөгийг илүү олгосон байна. Энэ нь НХХСайдын 2005 оны 55 дугаар тушаал “Дундаж цалин хөлс тодорхойлох журам”, ЭМНХСайдын 2000 оны 166 тоот тушаалын 2-р хавсралт “Ээлжийн амралтын олговор тооцох журмыг хэрэгжүүлэн ажиллах” тухай журамд заасныг мөрдөөгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Ээлжийн амралтын тооцооллыг холбогдох журмын дагуу үнэн зөв хийж байх талаар зөвлөмж өгөх

5. Салбарын тэргүүний ажилтан цолтой ажилтнуудад сар бүрийн 10.0 мянга, нийт 3.1 сая төгрөгийн нэмэгдэл олгосон байна. Мөн тэтгэвэрт гарсан ахмад настуудад эрчим хүчний салбарын тэргүүний ажилтны сар бүрийн 10.0 мянган төгрөгийн нэмэгдэл олгосон байдал ажиглагдлаа.

Шийдвэрлэсэн нь: Хамтын гэрээ хэлэлцээр нь холбогдох хууль тогтоомжтой нийцэж байх талаар зөвлөмж өгөх

6. Жилийн үр дүнгийн нэмэгдэл цалин олгоход ТУЗ-ийн 2015 оны 12-р сарын 18-ны өдрийн 24 тоот тогтоолоор шинэчлэн батлагдсан журмаар 3 сараар олгоно гэж заасан боловч 3.5 сараар олгож 24.6 сая төгрөг илүү олгосон байгаа нь санхүүгийн тайлангийн оршин байх, хэмжилт, иж бүрэн байх, үнэн зөв байдал, тайлагнал гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Жилийн үр дүнгийн нэмэгдэлд илүү тооцож олгосон 24.6 сая төгрөгийг нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоох

7. Ажиллагсдад удаан жилийн нэмэгдлийг хэвийн нөхцөлд 2-4 жил ажилласан тохиолдолд үндсэн цалингийн 15 хувиар тооцон 11.0 сая төгрөг олгосон байдал ажиглагдлаа. Энэ нь ЗГ-ын 1995 оны 96-р тогтоолоор баталсан “Төрийн захиргааны албан хаагчид төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл олгох журам”-ын 2-р хавсралтад “16-20 жил ажилласан бол 15 хувийн нэмэгдэл олгоно” гэж заасантай нийцэхгүй байна

Шийдвэрлэсэн нь: Удаан жилийн нэмэгдлийг олгохдоо ЗГ-ын 1995 оны 96-р тогтоолын 2-р хавсралтыг удирдлага болгох талаар албан шаардлага хүргүүлэх

8. Оны эцсийн үндсэн хөрөнгө, бараа материалын тооллогын тооцоог нэгтгэж баримтжуулаагүй, тайлан илтгэх хуудас байхгүй байгаа нь НББ-ийн тухай хуулийн 12.2.1-д “жилийн санхүүгийн тайлан гаргахын өмнө хөрөнгө, төлбөр тооцооны тооллогыг заавал хийнэ” гэснийг мөрдөөгүй байна.

Шийдвэрлэсэн нь: НББ-ийн тухай хуулийг мөрдөж ажиллах талаар зөвлөмж хүргүүлэх

9. Борлуулалтын программ нь авлагын дэлгэрэнгүй бүртгэлийн эхний болон эцсийн үлдэгдлийг сар бүрийн үлдэгдлийг өссөн дүнгээр гаргадаг. Энэ нь санхүүгийн тайлангийн оршин байх, хэмжилт, иж бүрэн байх, үнэн зөв байдал, тайлагнал гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Борлуулалтын программыг НББ-ийн хууль, стандартад нийцүүлэн засаж сайжруулах талаар зөвлөмж өгөх

10. Хас банкинд 2016 оны 2 дугаар сарын 1-нд жилийн 15.1 хувийн хүүтэй, 9 сарын хугацаатай 5001650165 тоот хуримтлах хадгаламжийн данс нээлгэж 100.0 сая төгрөг шилжүүлж 11.9 сая төгрөгийн хүүний орлого олсон. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 27.1 дэх заалтын дагуу эрх бүхий байгууллагын шийдвэрийг үндэслэх, мөн хуулийн 28.5 дахь заалт “Төрийн өмчийн түрээс, ашиглалтын орлогын төлбөрийг улсын төсөвт оруулна” гэсэн заалтыг мөрдөөгүй байна.

Шийдвэрлэсэн нь: ТУЗ-өөр шийдвэр гаргуулж, зөвшөөрөл авсны үндсэн дээр хадгаламжийн данс нээх, хадгаламжийн хүүний орлогын тодорхой хувийг төсөвт төвлөрүүлдэг байх талаар зөвлөмж өгөх

Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл:

“Өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК-ийн 2016 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 1,319.3 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрсэн ба 547.1 сая төгрөгийн алдаа зөрчилд албан шаардлага хүргүүлж, 70.3 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 775.8 сая төгрөгийн алдаа зөрчлийг арилгах талаар аудитын зөвлөмж өгсөн болно.

Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт:

“Өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК-ийн 2015 оны санхүүгийн тайланд “Шинэ их тэрбум Аудит” ХХК-аас хийсэн аудитаар 4 зөвлөмж өгсөн бөгөөд эдгээр зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлсэн байна.

Хязгаарлалттай санал дүгнэлт

Дээрх алдаа зөрчлийн нөлөөллийг эс тооцвол “Өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК-ийн 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй тайлан, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүд нь холбогдох хууль, СТОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударгаар илэрхийлэгдсэн байна.

Аудитлагдсан санхүүгийн тайлан 5 хуудас, хавсралтууд хуудас хавсаргав.



“ӨМНӨД БҮСИЙН ЦАХИЛГААН ТҮГЭЭХ СҮЛЖЭЭ” ТӨХК-ИЙН 2016 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН

Менежментийн захидал

Тэргүүлэх ач холбогдол №1 зүйлс:

Асуудал. 1

Мөнгөн хөрөнгийн талаар

Асуудал. 2

Худалдан авах ажиллагааны талаар.....

Асуудал. 3

Шагнал урамшууллын талаар.....

Асуудал. 4

Борлуулалтын программын талаар.....

Асуудал. 5

Хөрөнгийн тооллого, тооцооны талаар

Асуудал. 6

Урт хугацаат зээлийн талаар.....

Асуудал. 7

Засаглалыг сайжруулах талаар.....

2017 оны 3 дугаар сар

Менежментийн захидал

Үндэсний аудитын газар аудитын явцад илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг “Өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК-ийн удирдлагад зориулж бэлтгэсэн бөгөөд түүнд хяналтын сул тал, горимыг өөрчлөх замаар хяналтыг сайжруулах зөвлөмжийг өглөө.

Энэхүү менежментийн захидлын агуулга АОУС-ын дагуу хийгддэг ТАБ-ын аудитын горимоос урган гарсан болно. Бидний хэрэгжүүлсэн горим, сорил нь санхүүгийн тайлангийн санал дүгнэлт гаргахад зориулагдсан.

Тиймээс аудитын зөвлөмж нь дахин хяналт хийх үеийн нөхцөл байдлын талаархи бидний үнэлэлт, дүгнэлтийг тусгаж байгаа болно.

Төрийн аудитын байгууллага энэхүү зөвлөмжийг та бүхний бүртгэл, тайлагнал, хяналтын үйл ажиллагааг сайжруулах зорилготой бөгөөд харин зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан “Өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК-ийн санхүүгийн ажилтнуудад талархал илэрхийлье.

Аудиторын ажиглалт

1. Хас банкинд 2016 оны 2 дугаар сарын 1-нд жилийн 15.1 хувийн хүүтэй, 9 сарын хугацаатай 5001650165 тоот хуримтлах хадгаламжийн данс нээлгэж 100.0 сая төгрөг шилжүүлж 11.9 сая төгрөгийн хүүний орлого олсон. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 27.1 дэх заалтын дагуу эрх бүхий байгууллагын шийдвэрийг үндэслэх, мөн хуулийн 28.5 дахь заалт “Төрийн өмчийн түрээс, ашиглалтын орлогын төлбөрийг улсын төсөвт оруулна” гэсэн заалтыг мөрдөөгүй байна.

2. Мөнгөн хөрөнгийн журналд 35.9 сая төгрөгийн харилцах дансны орлого зарлагын гүйлгээг зөрүүтэй бүртгэж тайлагнасан.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14.4.1, 14.4.5-д “Нягтлан бодох бүртгэлд аж ахуйн бүх ажил гүйлгээ, бүх орлогыг заавал бүртгэнэ” гэж заасантай нийцэхгүй байна.

Эрсдэлүүд

Хууль тогтоомж зөрчигдөх эрсдэлтэй

Аудиторын зөвлөмж

1. Төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэр гаргуулж, зөвшөөрөл авсны үндсэн дээр хадгаламжийн данс нээх, хадгаламжийн хүүний орлогын тодорхой хувийг төсөвт төвлөрүүлдэг байх
2. НББ-ийн тухай хуулийг хэрэгжүүлэн ажиллах, харилцах дансны гүйлгээг бүртгэлд бүрэн тусгаж тайлагнах

Үйлчлүүлэгчийн хариу

1. Төсвийн хүндрэлтэй үед орлого олох, харилцах дансны сул чөлөөтэй үлдэгдлийг хугацаатай байршуулан хүүний орлого олсон ба компанийн жилийн эцсийн тайлан хамгаалалтаар ТУЗ-ын хуралд танилцуулсан.
2. Зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллана.

Аудиторын ажиглалт

Тендер сонгон шалгаруулалт болон Худалдан авах ажиллагааг холбогдох хууль, журмын дагуу үнэн зөв шударга явагдаагүй байна. ТУЗ-аас сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх талаар шийдвэр гараагүй боловч сонирхлын зөрчилтэй хэлцэл хийсэн, тендерийн сонгон шалгаруулалт явуулахдаа үнэлгээний хороо хараат бус байдлаа алдсан байдал ажиглагдлаа. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай, Компанийн тухай хуульд заасантай нийцэхгүй байна.

Аудиторын зөвлөмж

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай, Компанийн тухай хуулийг хэрэгжүүлэн ажиллах

Эрсдэлүүд

Хууль тогтоомж зөрчигдөх эрсдэлтэй.

Үйлчлүүлэгчийн хариу

Зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллана.

Аудиторын ажиглалт

1. Тайлант онд ойн арга хэмжээ болон шагнал урамшуулалд гүйцэтгэх захирлын тушаалаар 30.1 сая төгрөг зарцуулсан нь ЗГ-ын 2014 оны 5 дугаар сарын 10-ны өдрийн “Төсвийг хэмнэлтийн горимд шилжүүлэх зарим арга хэмжээний тухай” 147 тоот тогтоолын 3.6-д “улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр, ялангуяа төсвийн нэмэлт орлого, хандив болон тусламжийн орлогоор гадаад, дотоодын тойрон аялал, зугаалга, ой тэмдэглэх арга хэмжээ, урлагийн наадам, уралдаан тэмцээн зохион байгуулахгүй байх” гэснийг зөрчсөн байна

2. Ажиллагсдад удаан жилийн нэмэгдлийг хэвийн нөхцөлд 2-4 жил ажилласан тохиолдолд үндсэн цалингийн 15 хувиар тооцон 11.0 сая төгрөг олгосон байдал ажиглагдлаа. Энэ нь ЗГ-ын 1995 оны 96-р тогтоолын 2-р хавсралт “Ажилласан хугацааны нэмэгдэл олгох журам”-д заасантай нийцэхгүй байна.

Эрсдэлүүд

Хууль тогтоомж зөрчигдөх эрсдэлтэй.

Аудиторын зөвлөмж

1. ЗГ-ын 2014 оны 5 дугаар сарын 10-ны өдрийн “Төсвийг хэмнэлтийн горимд шилжүүлэх зарим арга хэмжээний тухай” 147 тоот тогтоолыг хэрэгжүүлэн ажиллах

2. Удаан жилийн нэмэгдлийг олгохдоо ЗГ-ын 1995 оны 96-р тогтоолын 2-р хавсралт “Ажилласан хугацааны нэмэгдэл олгох журам”-ыг баримтлах

Үйлчлүүлэгчийн хариу

Эрчим хүчний салбарын хамтын хэлэлцээрийн дагуу олгосон. Зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллана.

Асуудал 4: Борлуулалтын программын талаар	Тэргүүлэх ач холбогдол №1
--	----------------------------------

Аудиторын ажиглалт

Борлуулалтын программ нь авлагын дэлгэрэнгүй бүртгэлийн эхний болон эцсийн үлдэгдлийг сар бүрийн үлдэгдлийг өссөн дүнгээр гаргадаг. Энэ нь санхүүгийн тайлангийн оршин байх, хэмжилт, иж бүрэн байх, үнэн зөв байдал, тайлагнал гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Аудиторын зөвлөмж

Борлуулалтын программыг НББ-ийн хууль, стандартад нийцүүлэн засаж сайжруулах

Эрсдэлүүд

Санхүүгийн мэдээ тайлан буруу илэрхийлэгдэх, мэдээлэл хэрэглэгчдэд буруу мэдээлэл хүрэх эрсдэлтэй

Үйлчлүүлэгчийн хариу

Зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллана.

Асуудал 5: Хөрөнгийн тооллого, тооцооны талаар	Тэргүүлэх ач холбогдол №1
---	----------------------------------

Аудиторын ажиглалт

Тайлант хугацаанд үндсэн хөрөнгө, бараа материалын тооллогын тооцоог нэгтгэж баримтжуулаагүй, тайлан илтгэх хуудас байхгүй байгаа нь НББ-ийн тухай хуулийн 12.2.1-д “жилийн санхүүгийн тайлан гаргахын өмнө хөрөнгө, төлбөр тооцооны тооллогыг заавал хийнэ” гэснийг мөрдөөгүй байна.

Аудиторын зөвлөмж

НББ-ийн тухай хуулийн дагуу үндсэн хөрөнгийн тооллогыг чанартай гүйцэтгэж, тооцоог нэгтгэн дүгнэж тайлагнадаг байх

Эрсдэлүүд

Өмч хөрөнгө дутагдах, шамшигдах, эрсдэлтэй

Үйлчлүүлэгчийн хариу

Зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллана.

Асуудал 6: Урт хугацаат зээлийн талаар	Тэргүүлэх ач холбогдол №1
---	----------------------------------

Аудиторын ажиглалт

“Өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК-ийн эхлэлтийн балансад “Эрчим хүчний төсөл”-ийн 5303-MOG дугаартай дамжуулан зээлдүүлэх гэрээний 929.7 сая төгрөгийн урт хугацаат зээлийн өглөг “ДзДЦС”ТӨХК-аас шилжиж ирсэн. 2015 онд тус 2 байгууллага тооцоо нийлж уг зээлийн 242.8 сая төгрөгийг “ДзДЦС” ТӨХК хариуцахаар болж “ӨБЦТС” ТӨХК 686.9 сая төгрөгийн урт хугацаат зээлийн өглөгтэй байхаар тооцоо нийлсэн байна. Сангийн яаманд “Өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК нь албан тоот явуулсан, шийдвэр ирээгүй байна. Аудитын компанийн зүгээс лавлагаа хүссэн албан тоот илгээсэн боловч хариу ирүүлээгүй.

Аудиторын зөвлөмж

Сангийн Яамтай урт хугацаат зээлийн гэрээ байгуулах, зээлийн үлдэгдлийг тулган баталгаажуулах

Эрсдэлүүд

Хууль тогтоомж зөрчигдөх эрсдэлтэй

Үйлчлүүлэгчийн хариу

Зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллана.

Асуудал 7: Засаглалыг сайжруулах талаар

Тэргүүлэх ач холбогдол №1

Аудиторын ажиглалт

2013 оноос 2016 оны эхний хагас жилийн хугацааны төлөөлөн удирдах зөвлөлийн тогтоол, шийдвэртэй танилцсан боловч үдэж хавтаслаагүй, дугаарлан архивлаагүй, архивын нэгж болгон хадгалаагүй, ТУЗ-ийн хурлын тэмдэглэл бүрэн гүйцэд биш дутуу байгаа байдал ажиглагдлаа.

Мөн Компанийн тухай хуулийн 81.4.1-д “аудитын хороо нь компанийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэлийг олон улсын стандартад нийцүүлэх, дотоод хяналтын болон эрсдэлийн удирдлагын үйл ажиллагаа, санхүүгийн тайлан, санхүү эдийн засгийн бусад мэдээллийн үнэн бодит байдалд хяналт тавих”, 81.4.4-д “их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцэлд хяналт тавих, дүгнэлт гаргах” гэснийг мөрдөөгүй байна.

Мөн хуулийн 82.2.3-д “Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга нь хувьцаа эзэмшигчдийн болон төлөөлөн удирдах зөвлөлийн хурлын тэмдэглэлийг хөтлөх, гарах шийдвэрийг зохих журмын дагуу баталгаажуулах, хэрэгжилтэд хяналт тавих үүрэг хүлээнэ” гэснийг мөрдөөгүй байна.

Эрсдэлүүд

Хууль тогтоомж зөрчигдөх, мэдээлэл хэрэглэгчдэд үнэн зөв, бодит мэдээлэл цаг хугацаандаа хүрэхгүй байх эрсдэлтэй.

Аудиторын зөвлөмж

Компанийн тухай хуулийг мөрдөж ажиллах, засаглалыг сайжруулах, хариуцсан ажлаа чанартай хийж гүйцэтгэж байх

Үйлчлүүлэгчийн хариу

Зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллана.

ӨМНӨД БҮСИЙН ЦАХИЛГААН ТҮГЭЭХ СҮЛЖЭЭ ТӨХК
АУДИТЛАГДСАН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН
2016 ОНЫ 12-Р САРЫН 31-НЭЭРХ
(төгрөгөөр)

ХӨРӨНГӨ

Үзүүлэлт	2015.12.31	2016.12.31	Аудитлагдсан үлдэгдэл
1. Эргэлтийн хөрөнгө			
Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө	341,455,587.26	569,139,443.60	569,139,443.60
Дансны авлага	100,744,957.88	61,861,649.38	61,861,649.38
Татвар, НДШ-ийн авлага	854,162.14	10,136,238.38	10,136,238.38
Бусад авлага			-
Бараа материал	87,869,370.46	161,706,995.39	161,706,995.39
Мал амьтад			-
Бусад эргэлтийн хөрөнгө			-
Урьдчилж төлсөн зардал/тооцоо	9,395,430.05	8,946,544.68	8,946,544.68
Эргэлтийн хөрөнгийн дүн	540,319,507.79	811,790,871.43	811,790,871.43
2. Эргэлтийн бус хөрөнгө			
Үндсэн хөрөнгө	14,507,342,928.36	14,241,937,228.82	14,241,937,228.82
Биет бус хөрөнгө	7,777,083.38	7,955,383.38	7,955,383.38
Биологийн хөрөнгө			
Урт хугацаат хөрөнгө оруулалт			
Хайгуул үнэлгээний хөрөнгө	-	-	-
Хойшлогдсон татварын хөрөнгө			
Хөрөнгө оруулалтбн зориулалттай үл хөдлөх хөрөнгө			-
Бусад эргэлтийн бус хөрөнгө	-	-	-
Эргэлтийн бус хөрөнгийн дүн	14,515,120,011.74	14,249,892,612.20	14,249,892,612.20
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	15,055,439,519.53	15,061,683,483.63	15,061,683,483.63

ӨМНӨД БҮСИЙН ЦАХИЛГААН ТҮГЭЭХ СҮЛЖЭЭ ТӨХК
АУДИТЛАГДСАН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН
2016 ОНЫ 12-Р САРЫН 31-НЭЭРХ
(төгрөгөөр)

ӨР ТӨЛБӨР БА ЭЗЭМШИГЧДИЙН ӨМЧ

Үзүүлэлт	2015.12.31	2016.12.31	Аудитлагдсан үлдэгдэл
1. Богино хугацаат өр төлбөр			
Дансны өглөг	141,520,172.43	6,899,397.77	6,899,397.77
Цалингийн өглөг	24.22	18,415.38	18,415.38
Татварын өглөг	5,058,440.28	29.30	29.30
НДШ-ийн өглөг	113,686.19		
Хүүгийн өглөг			
Ногдол ашгийн өглөг			
Банкны богино хугацаат зээл			
Нөөц /өр төлбөр/			
Бусад богино хугацаат өр төлбөр	2,749,000.00	6,776,643.00	6,776,643.00
Урьдчилж орсон орлого	12,243,456.00	37,605,781.00	37,605,781.00
Богино хугацаат өр төлбөрийн дүн	161,684,779.12	51,300,266.46	51,300,266.46
2. Урт хугацаат өр төлбөр			
Урт хугацаат зээл	686,882,621.51	686,882,621.51	686,882,621.51
Бусад урт хугацаат өглөг	-	-	-
Урт хугацаат өр төлбөрийн дүн	686,882,621.51	686,882,621.51	686,882,621.51
Өр төлбөрийн нийт дүн	848,567,400.63	738,182,887.97	738,182,887.97
Эзэмшигчдийн өмч			
Өмч: а) Төрийн	6,956,718,528.54	14,240,798,494.53	14,240,798,494.53
б) Хувийн	-	-	-
Хувьцаат капиталын дүн	6,956,718,528.54	14,240,798,494.53	14,240,798,494.53
Нэмж төлөгдсөн капитал			
Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл			
Эзэмшигчдийн өмчийн бусад хэсэг	7,624,134,091.39	370,127,983.39	370,127,983.39
Хуримтлагдсан ашиг /алдагдал/	(373,980,501.04)	(287,425,882.27)	(287,425,882.27)
Эзэмшигчдийн өмчийн дүн	14,206,872,118.89	14,323,500,595.65	14,323,500,595.65
ӨР ТӨЛБӨР БА ЭЗЭМШИГЧДИЙН ӨМЧИЙН ДҮН	15,055,439,519.52	15,061,683,483.63	15,061,683,483.63

ӨМНӨД БҮСИЙН ЦАХИЛГААН ТҮГЭЭХ СҮЛЖЭЭ ТӨХК
АУДИТЛАГДСАН ОРЛОГЫН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН
2016 ОНЫ 12-Р САРЫН 31-НЭЭРХ
(төгрөгөөр)

	2015.12.31	2016.12.31	Аудитлагдсан дүн
Борлуулалтын орлого	4,225,918,734.55	4,833,549,346.36	4,833,549,346.36
Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	3,773,477,487.17	3,903,718,501.56	3,903,718,501.56
Нийт ашиг (алдагдал)	452,441,247.37	929,830,844.80	929,830,844.80
Түрээсийн орлого			
Хүүгийн орлого	1,542,291.65	26,632,226.07	26,632,226.07
Ноогдол ашгийн орлого			
Эрхийн шимтгэлийн орлого			
Бусад орлого	292,019,491.20	161,519,618.27	161,519,618.27
Борлуулалт маркетингийн зардал	2,137,468.17	5,743,087.73	5,743,087.73
Ерөнхий ба удирдлагын зардал	705,549,776.90	951,053,548.68	951,053,548.68
Санхүүгийн зардал			
Бусад зардал			
Гадаад валютын ханшийн зөрүүний олз/гарз/			
Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз /гарз/			
Биет бус хөрөнгө данснаас хассаны олз /гарз/			
хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз/гарз/			
Бусад ашиг /алдагдал/	(19,276,933.29)	(61,206,476.32)	(61,206,476.32)
Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	19,038,851.86	99,979,576.42	99,979,576.42
Орлогын татварын зардал	1,911,373.19	9,997,957.64	9,997,957.64
Тайлант үеийн орлогын татварын зардал			
Хойшлогдсон татварын зардал /орлого/			
Татварын дараах ашиг /алдагдал/	17,127,478.67	89,981,618.78	89,981,618.78
Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг /алдагдал/			
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	17,127,478.67	89,981,618.78	89,981,618.78
Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү			
Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүүний			
Бусад олз /гарз/			
Орлогын нийт дүн	17,127,478.67	89,981,618.78	89,981,618.78
Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг /алдагдал/			

"Өмнөд Бүсийн Цахилгаан Түгээх Сүлжээ" ТӨХК
Санхүүгийн тайлангийн аудит
2016 оны 12 дугаар сарын 31-нээр дуусгавар болсон

ӨМНӨД БҮСИЙН ЦАХИЛГААН ТҮГЭЭХ СҮЛЖЭЭ ТӨХК
АУДИТЛАГДСАН ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН
2016 ОНЫ 12-Р САРЫН 31-НЭЭРХ
(төгрөгөөр)

	Өмч	Нэмж төлөгдсөн капитал	Хөрөнгө дахин үнэлгээний нэмэгдэл	Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц	Эзний өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
2014 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	6,311,512,940.54			-	1,057,175,372.35	(391,107,979.71)	6,977,580,333.18
Нягтлан бодох бзртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга							-
Залруулсан үлдэгдэл	6,311,512,940.54				1,057,175,372.35	(391,107,979.71)	6,977,580,333.18
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)						17,127,478.67	17,127,478.67
Бусад дэлгэрэнгүй орлого							-
Өмчит гарсан өөрчлөлт	645,205,588.00				6,566,958,719.04		7,212,164,307.04
Зарласан ноогдол ашиг							-
Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн							-
2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	6,956,718,528.54				7,624,134,091.39	(373,980,501.04)	14,206,872,118.89
Нягтлан бодох бзртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга							-
Залруулсан үлдэгдэл	6,956,718,528.54				7,624,134,091.39	(373,980,501.04)	14,206,872,118.89
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)						89,981,618.78	89,981,618.78
Бусад дэлгэрэнгүй орлого							-
Өмчит гарсан өөрчлөлт	7,284,079,965.99				(7,254,006,108.00)		30,073,857.99
Зарласан ноогдол ашиг						(3,427,000.00)	(3,427,000.00)
Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн						-	-
2016 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	14,240,798,494.53	-	-	-	370,127,983.39	(287,425,882.27)	14,323,500,595.65
Аудитаар залруулсан үлдэгдэл							-
2016 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	14,240,798,494.53	-	-	-	370,127,983.39	(287,425,882.27)	14,323,500,595.65

Хавсаргасан тэмдэглэлүүд нь энэхүү тайлангийн салиггүй хэсэг болно.

ӨМНӨД БҮСИЙН ЦАХИЛГААН ТҮГЭЭХ СҮЛЖЭЭ ТӨХК
АУДИТЛАГДСАН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН
2016 ОНЫ 12-Р САРЫН 31-НЭЭРХ
(төгрөгөөр)

	2015.12.31	2016.12.31	Аудитлагдсан дүн
1. Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ			
<u>Мөнгөн орлогын дүн (+)</u>	5,202,413,398.01	5,651,667,632.51	5,651,667,632.50
Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	4,726,728,825.98	5,562,902,828.74	5,562,902,828.74
Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	330,909.09	113,636.36	113,636.36
Буцаан авсан албан татвар			
Татаас, санхүүжилтийн орлого			
Бусад мөнгөн орлого	475,353,662.94	88,651,167.40	88,651,167.40
<u>Мөнгөн зарлагын дүн (-)</u>	4,840,271,946.87	5,368,993,330.06	5,368,993,330.06
Ажиллагчдад төлсөн	979,775,892.66	1,203,131,138.91	1,203,131,138.91
Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	244,181,289.00	284,400,000.00	284,400,000.00
Бараа материал худалдан авахад төлсөн	2,787,072,945.15	3,029,830,796.88	3,029,830,796.88
Ашиглалтын зардалд төлсөн	25,921,361.09	20,099,307.63	20,099,307.63
Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	63,215,500.00	72,207,665.00	72,207,665.00
Хүүний төлбөрт төлсөн			
Татварын байгууллагад төлсөн	267,920,905.03	374,276,931.00	374,276,931.00
Даатгалын төлбөрт төлсөн	7,093,642.00	3,386,540.00	3,386,540.00
Бусад мөнгөн зарлага	465,090,411.94	381,660,950.64	381,660,950.64
Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	362,141,451.14	282,674,302.45	282,674,302.44
2. Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ			
<u>Мөнгөн орлогын дүн (+)</u>	5,270,021.65	29,595,196.07	29,595,196.07
Үндсэн хөрөнгө борлуулсны орлого		-	-
Хөрөнгө оруулалт борлуулсны орлого			
Бусад урт хугацаат хөрөнгө борлуулсны орлого			
Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт	3,727,730.00	2,962,970.00	2,962,970.00
Хүлээн авсан хүүний орлого	1,542,291.65	26,632,226.07	26,632,226.07
Хүлээн авсан ногдол ашиг			
<u>Мөнгөн зарлагын дүн (-)</u>	82,790,989.00	81,158,642.18	81,158,642.18
Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	82,790,989.00	79,673,642.18	79,673,642.18
Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн		1,485,000.00	1,485,000.00
Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн			
Бусад урт хугацаат хөрөнгө олж эзэмшихэд төлсөн			
Бусдад олгосон зээл болон урьдчилгаа		-	-
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(77,520,967.35)	(51,563,446.11)	(51,563,446.11)
Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ			
<u>Мөнгөн орлогын дүн (+)</u>		-	-
Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан		-	-
Хувьцаа болон өмчийн бусад үнэт цаас гаргаснаас хүлээн авсан			
Төрөл бүрийн хандив			
Ханшийн зөрүү		-	-
<u>Мөнгөн зарлагын дүн (-)</u>		3,427,000.00	3,427,000.00
Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө		-	-
Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн			
Хувьцаа буцаан худалдаж авахад төлсөн			
Төлсөн ногдол ашиг		3,427,000.00	3,427,000.00
Бусад		-	-
Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн		(3,427,000.00)	(3,427,000.00)
Валютын ханшийн зөрүү			
Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	284,620,483.79	227,683,856.34	227,683,856.33
Мөнгө,түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	56,835,103.47	341,455,587.26	341,455,587.26
Мөнгө,түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	341,455,587.26	569,139,443.60	569,139,443.60